



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 20

Номгон

Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн  
салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 132 дугаар тогтоолоор баталсан “Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга: Аймгийн Засаг дарга

Орлогч дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн жендэрийн мэргэжилтэн

Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Олон нийттэй харилцах хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Цагдаагийн газрын дарга

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Аймгийн Эрчүүдийн холбооны тэргүүн

Гал голомт хөдөлгөөний Баянхонгор дахь салбарын тэргүүн /зөвшилцсөнөөр/

116001

“Өнөөгийн Баянхонгор” сонины эрхлэгч /зөвшилцсөнөөр/

2. Аймгийн Засаг дарга, салбар хорооны дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1. Салбар хорооны ажиллах журмыг боловсруулж 2017 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсугай.

2.2. Жендэрийн эрх тэгш байдлын аймгийн салбар хорооны ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР